



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны Ундраа группын байр,
Утас/факс: (976-11) 7011-8486
E-mail: info@eec.mn Веб: www.eec.mn

2020.04.01 № 01/27
танай _____-ны № _____-т

**АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Шалгалтын зохицуулалт хийх тухай” 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/118 дугаар тушаалын 2 дахь заалтын дагуу анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээ /дүн/-г тооцох аргачлал, хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Энэхүү аргачлал, зөвлөмжийг өөрийн харьяа ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлж, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна уу.

Хавсралт 6 хуудастай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ

ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАН-ЭРДЭНЭ



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Шалгалтын зохицуулалт хийх тухай” 2020 оны А/118 дугаар тушаалын 2 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан “Боловсролын үнэлгээний төвийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдмэл агуулга бүхий шалгалтын үнэлгээ /дүн/-г тооцох аргачлалыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан аргачлалыг 2019-2020 оны хичээлийн жилд мөрдсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэлгээ хөгжүүлэлтийн хэлтсийн дарга /М.Гантуяа/, Шалгалт, судалгаа хариуцсан хэлтсийн дарга /Л.Ганбат/ нарт даалгасугай.


ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ж. ГАН-ЭРДЭНЭ

00201128

Боловсролын үнэлгээний төвийн захирлын
2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн
А/46 дугаар тушаалын хавсралт



АНГИ ДЭВШИХ БОЛОН УЛСЫН ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭ /ДҮН/-Г ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээ /дүн/-г тооцоход энэхүү аргачлалыг мөрдөнө.
- 1.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 4.2, 5.3-д заасан “нэгдмэл агуулга” бүхий шалгалтын үнэлгээ /дүн/-г Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан “Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлал”-ын дагуу тооцно. Ийнхүү шалгалтын үнэлгээний дундаж хувь тооцоход суралцагчийн тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээ, болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тушаал, шийдвэрүүд дэх цагийн төлөвлөлтийг үндэслэнэ. Үүнд:
 - БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01 өдрийн А/491 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө”
 - БСШУС-ын сайдын 2018 оны 08 дугаар сарын 06 өдрийн А/491 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын тусгай сургуулиудын сургалтын төлөвлөгөө”;
 - БСШУС-ын сайдын 2019 оны 08-р сарын 15 өдрийн А/511 дүгээр тушаалаар батлагдсан “ОУ-ын хөтөлбөрийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө” зэрэг болно.
- 1.3 Суралцагчийн 2019-2020 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтын үнэлгээ /дүн/-г тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцож, багшийн журнал, суралцагчийн хувийн хэрэг, суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээний холбогдох хэсэгт бичиж тэмдэглэнэ.
- 1.4 Аргачлал нь 2019-2020 оны хичээлийн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Хоёр. Суралцагчийн үнэлгээний дундаж хувь бодох аргачлал

- 2.1 Нэгдмэл агуулга бүхий шалгалтын үнэлгээний дундаж хувь тооцоход сургалтын төлөвлөгөөний дагуу судалж, үнэлэгдсэн хичээл бүрээр авсан үнэлгээ /хувь/-г тухайн хичээлийн 7 хоногт судалсан цагаар үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг 7 хоногт судалсан цагийн нийлбэрт хувааж /арифметикийн жинлэсэн дундаж/, аравны орны нарийвчлалтай бодож гаргана.

$$\text{Үнэлгээний дундаж хувь} = \frac{a_1 * S_1 + a_2 * S_2 + \dots + a_n * S_n}{S_1 + S_2 + \dots + S_n}$$

n - хичээлийн тоо

$a_1, a_2 \dots a_n$ – сургалтын төлөвлөгөөний дагуу судалж үнэлэгдсэн заавал болон сонгон судалсан, төрөлжсөн эсхүл гүнзгийрүүлэн судалсан хичээлийн үнэлгээ /хувь/

$S_1, S_2 \dots S_n$ - сургалтын төлөвлөгөөний дагуу тухайн хичээлийг 7 хоногт судалсан цаг

Жишээ – 1: 3 дугаар ангийн сурагч А-ийн нэгдмэл агуулгын шалгалтын үнэлгээг дараах байдлаар тооцно.

№	Хичээлийн нэр	Жилийн эцсийн дүн	7 хоногт судлах цаг
1	Монгол хэл	95	7
2	Иргэний ёс зүйн боловсрол	91	2
3	Математик	88	5
4	Хүн ба орчин	98	2
5	Дүрслэх урлаг, технологи	92	2
6	Хөгжим	90	2
7	Биеийн тамир	93	2

$$\text{Үнэлгээний дундаж хувь} = \frac{95 * 7 + 91 * 2 + 88 * 5 + 98 * 2 + 92 * 2 + 90 * 2 + 93 * 2}{7 + 2 + 5 + 2 + 2 + 2 + 2} = \frac{2033}{22} = 92,4$$

Сурагч А-ийн баримт бичиг /сурагчийн хувийн хэрэг/-т **92.4** гэсэн үнэлгээг тэмдэглэнэ.

2.2 “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт бүлгийн 4.2 дахь заалтыг үндэслэнэ. Анги дэвших шалгалтын чиглэлд тусгасан - *нэгдмэл агуулга бүхий шалгалт, сургууль сонгох шалгалт, суралцагч сонгох шалгалтын үнэлгээг тооцоходоо нэмэлт зохицуулалтыг баримтална.*

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл	Нэмэлт зохицуулалт
Бага боловсрол	III	1	<ul style="list-style-type: none"> Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/ 	<ul style="list-style-type: none"> Бага ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан хичээлүүдийн судлах цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно.
	IV	2	<ul style="list-style-type: none"> Сургууль сонгох 1 хичээл Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/ 	<ul style="list-style-type: none"> Сургуулийн удирдлагын түвшинд ярилцаж сонгоно. Сургууль сонгох хичээлээс бусад хичээлийг Бага ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно.
Суурь боловсрол	VI	3	<ul style="list-style-type: none"> Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 	<ul style="list-style-type: none"> Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Дунд ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-

			<ul style="list-style-type: none"> • Математик • Сургууль сонгох 1 хичээл 	<p>нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно.</p> <ul style="list-style-type: none"> • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Шалгалттай хичээлээс бусад хичээлээс сургуулийн удирдлагын түвшинд ярилцаж сонгоно.
	VII	3	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ • Математик • Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/ 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Дунд ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Шалгалттай хичээлээс бусад хичээлээс сургуулийн удирдлагын түвшинд ярилцаж сонгох бөгөөд тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.
	VIII	3	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ • Математик • Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/ 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Дунд ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Суралцагч нэг бүрээр өгөх шалгалтыг сонгуулж тухайн сонгосон хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.
Бүрэн дунд боловсрол	X	3	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ • Математик 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Ахлах ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

			<ul style="list-style-type: none"> • Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/ 	<ul style="list-style-type: none"> • Суралцагч нэг бүрээр өгөх шалгалтыг сонгуулж тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.
	XI	3	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ • Математик • Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/ 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Ахлах ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Суралцагч нэг бүрээр өгөх шалгалтыг сонгуулж тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

2.3 “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын Улсын шалгалт, түүний зохион байгуулалт бүлгийн 5.3-т заасан шалгалтын агуулгад суурь боловсролын түвшинд суралцагч дараах шалгалтуудыг өгөхөөр заасан.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл	Нэмэлт зохицуулалт
Бага боловсрол	V	3	<ol style="list-style-type: none"> 1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль 	<ul style="list-style-type: none"> • Шалгалтын чиглэлд дурдсан хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.
Суурь боловсрол	IX	4	<ol style="list-style-type: none"> 1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно/ <ul style="list-style-type: none"> - Байгалийн ухааны нэгдмэл агуулга - Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 	<ul style="list-style-type: none"> • Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Дунд ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Суралцагч бүрээр өгөх шалгалтыг сонгуулж Дунд ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. Сургалтын төлөвлөгөөнд байгалийн ухааны хичээлүүдэд хими, биологи, физикийн

			4. Гадаад хэл /англи хэл, орос хэл- аль нэгийг суралцагч сонгоно/	хичээлүүдийг тусгасан бол нийгмийн ухаанд газар зүй, нийгэм, иргэний ёс зүйн боловсрол, түүхийн хичээлүүдийг багтаан багцалсан. • Суралцагчдаар англи хэл болон орос хэлний хичээлээс аль нэгийг сонгуулж тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /хими, биологи, физик, газар зүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл- аль нэгийг суралцагч сонгоно.	Бүрэн дунд боловсролын түвшинд шалгалтын үр дүнг заавал судлах хичээлийн үнэлгээгээр тооцно. • Монгол хэл, бичиг, уран зохиол хичээлийн Ахлах ангийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд тусгасан цаг, жилийн эцсийн үнэлгээнд үндэслэн үнэлгээний дундаж хувь тооцох аргачлалын дагуу тооцно. • Математикийн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Суралцагч бүрээр өгөх шалгалтыг сонгуулж тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно. • Суралцагчдаар англи хэл болон орос хэлний хичээлээс аль нэгийг сонгуулж тухайн хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

2019 – 2020 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөө (А/491)-нд байгалийн ухаан (нийгмийн ухаан) нэгдмэл агуулгаар шалгалт өгөхөөр сонгосон суралцагчийн хувьд баримт бичиг /сурагчийн хувийн хэрэг, суурь боловсролын гэрчилгээ, үнэмлэх/-т тэмдэглэх үнэлгээг дараах аргачлалаар тооцно.

Жишээ-2 : Суурь боловсролын 9 дүгээр ангийг төгсөж буй нэгэн суралцагч нь байгалийн ухааны нэгдмэл агуулгаар шалгалт өгөхөөр сонгосон байна. Түүний жилийн эцсийн дүнг авч үзвэл: физикийн хичээлээр жилийн эцэст 100 хувь, биологийн хичээлээр 90 хувь, химийн хичээлээр 95 хувийн үнэлгээтэй шалгагдсан гэж үзье. Аргачлалыг дор харууллаа.

№	Судлагдахуун	IX анги	
		Жилийн эцсийн дүн, <i>a</i>	7 хоногт судалсан цаг, <i>S</i>
1	Физик	100	2
2	Биологи	90	2
3	Хими	95	2

$$\text{Үнэлгээний дундаж хувь} = \frac{100 * 2 + 90 * 2 + 95 * 2}{2 + 2 + 2} = \frac{570}{6} = 95,0$$

Суралцагчийн хувийн хэрэг болон гэрчилгээн дээр тавигдах байгалийн ухааны нэгдмэл агуулгын шалгалтын дүн хэсэгт **95.0** хувь гэсэн үнэлгээ тавигдах юм.

Харин суралцагч нь нийгмийн ухааны нэгдмэл агуулгаар шалгалт өгөхөөр сонгосон бөгөөд түүний жилийн эцсийн дүнг авч үзье.

№	Судлагдахуун	IX анги	
		Жилийн эцсийн дүн, <i>a</i>	7 хоногт судалсан цаг, <i>S</i>
1	Иргэний ёс зүйн боловсрол	100	2
2	Газар зүй	97	1
3	Түүх	98	2
4	Нийгэм судлал	88	1

$$\text{Үнэлгээний дундаж хувь} = \frac{100 * 2 + 97 * 1 + 98 * 2 + 88 * 1}{2 + 1 + 2 + 1} = \frac{581}{6} = 96,8$$

Суралцагчийн хувийн хэрэг болон гэрчилгээн дээр тавигдах нийгмийн ухааны нэгдмэл агуулгын шалгалтын дүн хэсэгт **96.8** хувь гэсэн үнэлгээ тавигдах юм.

2.4 БСШУС-ын сайдын 2018 оны 08 дугаар сарын 06 өдрийн А/491 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын тусгай сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд тусгаснаар:

2.4.1 бага ангийн улсын шалгалтыг: математик, монгол хэл, нийгэм ахуйн баримжаа хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

2.4.2 суурь боловсролын түвшинд математик, монгол хэл, технологи /мэргэжлийн чиг баримжаа/ хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.